



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Компанийн засаглалын зэрэглэл тогтоох
ажлыг зохион байгуулах тухай



Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Компанийн засаглалын зэрэглэл тогтоох аргачлалын стандартыг боловсруулж батлан, түүний хэрэгжилтийг Хороотой зөвшилцөн зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг Компанийн засаглалын үндэсний зөвлөл /Д.Ганбаяр/-д үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийн өгсөн үүргийн явц байдлын талаар Хороонд ажлаа тайлагнах үедээ танилцуулж байхыг Компанийн засаглалын үндэсний зөвлөл /Д.Ганбаяр/-д даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 209 дүгээр тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН